

ТЕХНИК ИМПОРТ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Монгол улсын Компанийн тухай хууль, компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 01-р сарын 25-ны өдрийн “Үүрэг даалгавар өгөх тухай” 9/227 тоот албан бичиг, 2021 оны 01-р сарын 27-ны өдрийн “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Дугаар 45 тоот албан бичиг болон Улсын Онцгой Комиссын шийдвэрийг тус тус удирдлага болгон 2021 оны 04-р сарын 13-ны өдрийн 15 цагт Техник импорт ХК-ийн “Хурлын танхим”-д олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “ZOOM” платформ /цахим/ хэлбэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулж явуулав.

Хурал зохион байгуулах комисс хурлын саналын хуудсуудыг болон мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор цахим хуралд нэвтрэх эрх, нууц үгийг хуралд оролцохоор саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн цахим шуудан болон гар утсанд урьдчилан явуулсан ба хурлын Тооллогын комиссын бүртгэлийн үйл ажиллагаа цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигчдийн нэрсийг ҮЦТХТ ТӨХК-иас ирүүлсэн Техник импорт ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд байгаа нэрстэй тулган баталгаажуулж явуулав.

Хурлын тооллогын комиссын дарга Б.Лхамсүрэн 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт саналын эрхтэй 1 446 755 ширхэг энгийн хувьцаанаас 1 429 432 ширхэг хувьцаа эзэмшдэг 5 хувьцаа эзэмшигч цахимаар оролцож хурлын ирц 98,8%-тай байгааг илтгэж энэ нь компанийн “Дүрэм”-д заасан “Нийт саналын эрхтэй хувьцааны 65-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно” гэсэн заалтыг хангасныг хурлын даргад мэдээлж танилцуулав.

Техник импорт ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 02 сарын 25-ны өдрийн №01 тоот тогтоолын дагуу 2021 оны Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар томилогдсон Д.Ганцэцэг Тооллогын комиссоос ирүүлсэн хурлын ирцийн дүнг хуралд оролцогчдод мэдээлсний дараа компанийн ТУЗ-ын нарийн бичгийн дарга О.Бүжинлхам Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 сарын 25-ны өдрийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, тооллогын комиссыг томилсон талаарх тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Д.Ганцэцэг хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлуудыг батлах эсэх асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал хураахад нийт хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид санал нэгтэй зөвшөөрснөөр хурлын үйл ажиллагаа эхлэв.

2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцсэн ба хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээ, материалыг хэлэлцэх асуудал бүрээр телевизийн дэлгэц дээр тоон мэдээ, баримтаар харуулав. Үүнд:

1. Техник импорт ХК-ийн үйл ажиллагааны болон жилийн эцсийн санхүүгийн тайланд ТУЗ-аас өгсөн дүгнэлт
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, ногдол ашгийн тайлан
3. 2021 оны компанийн зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөө

4. ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Хурлын дарга Д.Ганцэцэг хувьцаа эзэмшигч та бүхэнд дэлгэц дээр хэлэлцэх асуудлуудын талаарх мэдээ, тайланг дэлгэрэнгүй харуулж байгаа учраас нэг бүрчлэн тайлбарлах шаардлагагүй гэж үзэж байна гээд хэлэлцэх асуудлуудтай холбогдуулан 2020 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг ковидтой холбож төлөвлөөгүй, цементийн нийлүүлэлт тасарсантай холбоотойгоор төлөвлөгөөний гүйцэтгэл тасарсан явдал гарсан, 2021 онд шинэ бүтэц, зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөсөн, 2 үндсэн албыг шинээр байгуулсан, 2021 оны төлөвлөгөө, зорилтыг өмнөх оноос бууруулахгүйгээр төлөвлөсөн, ковидтой холбоотойгоор банкны зээлийн гэрээг 1 жилийн хугацаатайгаар сунгасан талаарх нэмэлт мэдээ, тайлбарыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Ногдол ашгийн талаарх тайланг ТУЗ-ын нарийн бичгийн дарга О.Бүжинлхам хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Хурлаар хэлэлцсэн үндсэн 3 асуудлуудын дараагаар хурлын дарга Д.Ганцэцэг болон тооллогын комисс Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 880 дугаар тогтоолын дагуу батлагдсан санал хураах кумулятив аргыг хэрэглэх шинэ журмын талаар хуралд оролцогчдод уншиж танилцуулан жишээгээр тайлбарлаж өгөв.

Хурлын даргаас хэлэлцэх асуудлуудыг бүрэн танилцуулж хэлэлцэх асуудлуудтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдээс тавьсан асуултуудад хариулт, холбогдох тайлбар, мэдээллийг өгч дууссаны дараа хурлаар хэлэлцсэн асуудлаар саналын хуудсаар санал авахтай холбогдуулан саналын хуудсыг хэрхэн бөглөх талаар заавар, зөвлөмжийг Тооллогын комиссоос хувьцаа эзэмшигчдэд тайлбарлаж өгснөөр Тооллогын комиссоос санал хураалтыг явуулав.

Тооллогын комиссоос 2021 оны 04 сарын 13-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар

1. Техник импорт ХК-ийн үйл ажиллагааны болон жилийн эцсийн санхүүгийн тайланд ТУЗ-аас өгсөн дүгнэлт
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, ногдол ашгийн тайлан
3. 2021 оны компанийн зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөө
4. ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох /кумулятив арга/

асуудлаар тус тус саналын хуудсаар санал хураалт явуулж саналын хуудсуудыг тоолоход хуралд оролцсон нийт 5 хувьцаа эзэмшигчээс

1. Хэлэлцэх асуудал-1

Зөвшөөрсөн-5 Татгалзсан-0 Түдгэлзсэн-0

2. Хэлэлцэх асуудал-2

Зөвшөөрсөн-5 Татгалзсан-0 Түдгэлзсэн-0

3. Хэлэлцэх асуудал-3

Зөвшөөрсөн-5 Татгалзсан-0 Түдгэлзсэн-0

4. Хэлэлцэх асуудал-4

Зөвшөөрсөн-5 Татгалзсан-0 Түдгэлзсэн-0 дүнтэй санал өгөв.

Хүчингүй хуудас гараагүй байв.

Тооллогын комиссын дарга Б.Лхамсүрэн хурлаар хэлэлцсэн асуудал бүрээр санал хураалтын дүнг хувьцаа эзэмшигчдэд илтгэж 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолуудын төслийг батлуулахаар хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав.

Тооллогын комисс хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсуудыг 2021 оны 04 сарын 14-ний өдрийн 18 цаг хүртэл Lkhamsuren@technikimport.mn цахим хаягаар болон шуудангаар хүлээж авах болсныг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Хурлын дарга Д. Ганцэцэг хурлыг хааж “2021 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудыг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид бүгд дэмжиж саналаа өгсөн байна. Тооллогын комиссын тогтоол болон хурлаар хэлэлцсэн тогтоолын төслүүдийг батлах шийдвэрийг өнөөдрийн хурлаас гаргаж байна. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа эзэмшигч та бүхэнд баярлалаа. Хурлын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье” гэснээр хурлын ажиллагаа дуусав.

Хурал 16.50 минутанд дуусав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

О. Бүжинлхам

ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ